

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл №2

Ажлын хэсгийн хуралдаан 2006 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 15 цагт Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын хурлын танхимд болов. Хуралдааны эхэнд кадастрийн албаны үйл ажиллагаа болон геологийн мэдээллийн фондтой ажлын хэсгийн гишүүдийг газар дээр нь танилцуулав.

Хуралдаанд Д.Батбаяр, Л.Болд, Ц.Банзрагч, Г.Гэрэлт-Од, П.Эрдэнэжаргал, Батболд, Ц.Мөнхбаяр, Э.Сумъяа, зөвлөх Г.Цогтсайхан нар, Л.Зоригийн оронд дэд дарга Батбаяр, Л.Дондогийн оронд дэд ерөнхийлөгч Чимэдцэрэн, Н.Алгаагийн оронд Зоригт, Даваацэдэвийн оронд Наран нар оролцов. Гишүүн Ц.Даваадорж, О.Батмөнх, Г.Зинаамядар, Б.Батжаргал нар хурал, семинар давхацсан тул оролцож чадаагүй болно. Эрдэнэт үйлдвэрийн ерөнхий захирал Х.Наранхүү Улаанбаатарт байхгүй, Монголын алт корпорацийн ерөнхийлөгчид материал, зар хүрээгүй, Айвенхоу майнз, Бороо гоулд компанийн дэд ерөнхийлөгч нарт материал хүрсэн ч ирээгүй болно. Хуралдаанд Нээлттэй нийгэм форумын менежер Дорждарь, Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын ажилтан Энхмаа нар урилгаар оролцов.

Хуралдааныг ажлын хэсгийн ахлагч Д.Батбаяр нээж хуралдаанаар хэлэлцэх 3 асуудлыг 3 хоногийн өмнө гишүүдэд хүргэсэн тухай мэдээлээд нэмж асуудал хэлэлцүүлэх санал байгаа эсэхийг гишүүдээс асууж, санал гараагүй тул төлөвлөсөн асуудлаа хэлэлцэхээр тогтов.

ХЭЛЭЛЦСЭН нь: 1. Уул уурхайн үйлдвэр, аж ахуйн газрыг тус санаачлагад хамруулан тайлагнуулах шалгуур үзүүлэлтийг тогтоох, аж ахуйн нэгжийг сонгох тухай

Д.Батбаяр- Уул уурхайн үйлдвэр, аж ахуйн газрыг тус санаачлагад хамруулан тайлагнуулах шалгуур үзүүлэлтийг тогтоох, аж ахуйн нэгжийг сонгох тухай товч танилцуулав.

Асуулт, хариулт явагдав.

Батболд-одоогийн оруулж байгаа саналаар бол ил тод байгаа татвар, хураамжийн асуудлыг ил тод болгох гээд байна, аж ахуйн нэгжийн лицензийн тоо, талбайн хэмжээ гээд далд байгаа асуудлыг ил тод болгож болохгүй юү? Татвар бага төлдгийг ч хамруулж болохгүй юү?

Э.Сумъяа-Санаачлага нь аж ахуйн нэгж төлбөл мэдээл, улс авсан бол мэдээл, төлсөн, авсны хооронд аудит хийх л зорилготой тухай та бүхэнд өгсөн лавлах номд байгаа.

Г.Цогтсайхан-Дэлхийн банкнаас өгч байгаа зөвлөмжөөр бол зөвхөн улсад тушаасан татвар, төлбөр, хураамжийг ил тод болгох, улс авснаа ил тод болгох зорилготой, үүнээс цааш хэлбийлгэхгүй байхыг анхааруулж байгаа.

Л.Болд-татвар төлдөггүйг холбогдох байгууллагад уламжлаад шалгуулж болно шүү дээ. Хэрвээ татвар төлөхгүй байгаа бол гэмт хэргийн асуудал болох учир хуулийн хүрээнд шалгах ёстой. Манай газарт гэхэд төрийн сангийн дансанд орох сургалтын зардлыг гадаад данс гэж нээгээд хийж байсан зөв биш механизм байсан, ийм зүйлийг ил тод болгоно.

П.Эрдэнэжаргал-Лицензийн төлбөр аж ахуйн нэгжийн нэрээр ордоггүй юм уу?

Л.Болд-Мэдээлэл янз бүр байдаг. Лицензийн төлбөр гэхэд лицензийн дугаараар төлөгддөг тул аж ахуйн нэгжийн нэрээр гаргахад их ажил болох юм билээ, иймд нэгтгэж чаддаггүй.

Гишүүд санал гаргаж хэлэлцэн ярилцав:

Ц.Мөнхбаяр-Шалгуур дээр санал байна. Орлогын тал нь чухал. Лиценз, ашиглалтыг ил тод болгоё. Барьцтай хэсгээс нь эхэлье. Хэрвээ эдгээрийг барьж авахгүй өөр ажлын хэсэг хэрэгжүүлнэ гэвэл хэцүү. Нийгэмд гарч байгаа хуваарилалт нууц байна. Орлогоо нуусан хятадын компани 1 тэрбум төгрөг олсон гэсэн мэдээлэл бий. Байгаль хамгаалахад зарцуулж байгаа зардлыг оруулая.

П.Эрдэнэжаргал-Энэ санаачлага олон улсын санаачлага тул өөрийн зарчимтай. Аж ахуйн нэгж улсад хичнээнийг төлсөн, улс хэдийг авсан гэдгээ л ил тод болгоно гэж байгаа. Лицензийн төлбөрийг оруулж болно.

Г.Гэрэлт-Од-олон улсын тогтсон жишгээр нь явъя.

Г.Цогтсайхан-Дэлхийн банк гол юмнаасаа битгий хазай, санхүүгийн ил тод байдлыг ханга гэж байгаа. Цаг гарвал бусад асуудал уруу орж болно. Санаачлага нь дэлхийн бренд нэрийн хувьд хэрэглэгдэнэ. Хэрвээ орлогоо нуусан компани байгаа бол татварын байгууллагад өгөөд шалгуулж болно.

П.Эрдэнэжаргал-50 сая гэсэн шалгуурт лицензийн төлбөрийг оруулая.

Нүүрс ассоциаци Наран-Шалгуур үзүүлэлтийн 4-ыг бүх компанийн хамруулах байдлаар оруулах, босго тавьж болохгүй, бага ч гэсэн орлоготой компанийг оруулах хэрэгтэй. Гарын авлага дээр критерий тавина гэж байхгүй, дундаас нь өөрчилж болохгүй.

Батболд-Санаачлагын гарын авлагыг уншсан. Манайд төрийн алба сул байна, хууль муу хэрэгжиж байна. Ийм учир сонгодог утгаар нь биш өөрийн өвөрмөгц онцлогийг харгалзан хэрэгжүүлэх хэрэгтэй. Иргэдээс ирсэн мэдээлэл, төрийн бус байгууллагын мэдээллээр санаачлагад хамруулах гэж шалгуурт оруулая.

Наран-компани өөрийн хүсэлтээр аудитаа сонгох уу, гадаадын биш дотоодын аудитын байгууллагаар аудит хийлгэх саналтай.

П.Эрдэнэжаргал-Аудитын асуудал дараа яригдана.

Г.Цогтсайхан-Бусад орон гадаадын аудит сонгосон байсан. Бид аудитын зардал төлөвлөж байгаа. Улс авснаа бас аудит хийлгэх учир бид аудитын компанийг сонгоно.

Э.Сумъяа-Төв азийн орнууд, африкийн орнуудад аудитын байгууллага байхгүй, байсан ч олон улсын хэмжээнд зөвшөөрөгдөөгүй тул тэд гадаадын аудитын байгууллагаар аудит хийлгэдэг юм билээ. Санаачлагад нэгдсэн ихэнх орон тотаритар дэглэмтэй орнууд байгаа юм.

П.Эрдэнэжаргал-Тэгж ч бас хэлж болохгүй, Норвеги зэрэг орон ч нэгдсэн.

Дорждарь-Төлсөн, авсан гэсэн 2 тоон дээр аудит хийгдэх тул компани аудитаа өөрөө сонгохгүй. Харин компанийн санхүүгийн аудит бол өөр асуудал гэдгийг ялгах хэрэгтэй.

Чимэдцэрэн-манай улсад аудитын 50-иад компани бий, үүнээс мэргэшсэн нь 20-иод компани байгаа. Дэлхийн банк ирж шалгаад аудитын зарим компаниуд олон улсын стандартад нийцэж байгаа гэсэн үнэлгээ өгсөн. Хуулиар бол 50 саяас дээш төгрөгийн хөрөнгөтэй компани аудит хийлгэх ёстой. Иймд заавал 50 сая гээд яахав, орлогоор нь байвал ямар вэ? үйл ажиллагаа явуулаагүй ч гэсэн санаачлагад хамрагдах нь зөв.

Г.Цогтсайхан-Хүсч байгаа бүх аж ахуйн нэгжийг оруулж болно. Авсан, өгсөн нь зэрээ гарвал аудит хийлгэнэ.

Чимэдцэрэн-Олон улсын аудитын 4 компани энд салбараа нээсэн үйл ажиллагаа явуулж байгаа. Энд салбараа нээсэн компаниар аудит хийлгэх хуультай.

Л.Болд-Бид тендер зарлаад аудит хийлгэнэ. Аж ахуйн нэгж өөрийн санхүүгийн үйл ажиллагаанд хуулийн дагуу аудит хийлгэж болно. Авсан, өгсний хувьд бол бид зарлана. Тэгээд аудит хийлгэнэ гэж ойлгож байгаа.

Д.Эрдэнэжаргал-Шалгуур үзүүлэлтээс "сайн дураар" гэснийг хасая.

Г.Цогтсайхан-улс бүр өөр өөрийн хуулиар явж байгаа. Нигер улс энэ талаар сайн ажиллаж байгаа юм билээ. Азийн зарим орнууд хууль гаргаагүй байгаа. Хууль гаргаж бүгдийг санаачлагад хамруулж болно. Хууль гаргаж бүх аж ахуйн нэгжийг хамруулбал аудитын зардлыг улсын төсөвтөө тусгаж гаргаарай гэж Дэлхийн банк зөвлөж байгаа.

Чимэдцэрэн-Санаачлагад орсны ач холбогдол юу вэ?

Гишүүд аж ахуйн нэгж санаачлагад нэгдснээр дараахи ач холбогдол бий гэж харилцан ярилцав:

- Төлснөө ил тод мэдээлдэг болно;
- Компанийн нэр төрийн хэрэг болно;
- Аж ахуйн нэгжийг иргэд, төрийн бус байгууллага дэмждэг болно;
- Санаачлагад нэгдсэн компаниудад олон улсын зарим банкууд зээл олгоно гэж зарлаж байгаа тул түүнд хамрагдаж болно;
- Хөрөнгө оруулалтын биржүүдэд бүртгүүлэхэд санаачлагад нэгдсэн байхыг нэг үзүүлэлт болгож байгаа;
- Улс оронд тогтвортой байдал бий болно.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Гишүүдийн саналыг хэлэлцүүлж байгаа асуудалд тусган цаашид улам боловсронгуй болгохоор тогтов.

ХЭЛЭЛЦСЭН нь: Ажлын хэсгийн 6 дугаар сард хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнийг боловсруулах гишүүдийн хуваарь

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гишүүдийн хуваарийг гаргаж байгаа нь 7 дугаар сард баяр наадам болно, дараа нь амралтын үе эхлэх тул ажлын төлөвлөгөөний 6-7 дугаар сард

хийх ажлаа энэ 6 дугаар сарын 20 гэхэд хийх, 6 дугаар сарын сүүлээр ажлын хэсгийн хурал хийж хэлэлцэх зорилготой тухай танилцуулж, төлөвлөгөөний заалт бүрээр гишүүдээс санал авав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Ажлын хэсгийн гишүүдийн саналын дагуу төлөвлөгөөний 2 дугаар заалтад 1 гишүүн, 3 дугаар заалтад 3 гишүүн, 4 дүгээр заалтад 2 гишүүн, 5 дугаар заалтад 2 гишүүн, 6 дугаар заалтад 1 гишүүн, 7 дугаар заалтад 2 гишүүн, 8 дугаар заалтад 1 гишүүний нэрийг хариуцан хэрэгжүүлэх гишүүдийн нэр дээр нэмж тусган төлөвлөгөөг зөвшөөрөв. Энэ төлөвлөгөөнд тусгагдсан ажлаа ахлан хэрэгжүүлж байгаа гишүүд хариуцан бусад гишүүдээ зохион байгуулан боловсруулж 6 дугаар сарын 20 гэхэд ажлын хэсгийн нарийн бичгийн даргад өгөхөөр тогтов.

ХЭЛЭЛЦСЭН нь: Олборлох үйлдвэлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ажиллах журмын төсөл

Д.Батбаяр-энэ төслийг та бүхнээс санал авч байгаа учир одоо хэлэлцэлгүй та нар аажуу уужуухан үзээд саналаа өгнө үү. Та бүхний саналыг тусган дараагийн хуралдаанаар хэлэлцэн батлах зорилготой гэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Ажлын хэсгийн ажиллах журмын төслийн талаархи саналаа гишүүд 6 дугаар сарын 10 гэхэд бичгээр ажлын хэсгийн нарийн бичгийн даргад өгөхөөр тогтов.

Ажлын хэсгийн хуралдаан 17.05 цагт дуусав.

Хуралдааны тэмдэглэл хөтөлсөн



Э.Сумъяа

Танилцсан:



Д.Батбаяр